



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 07

№ 01/12 В.УА-2018/117/СТА-ТШС Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Цагаандэлгэр сумын Соёлын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 2,255,500.00 /хоёр сая хоёр зуун тавин таван мянга таван зуун/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

1. Хэмнэлтийн горимд шилжих тухай тогтоол зөрчиж байгууллагын барилга байгууламжид 752,000.00 /долоон зуун тавин хоёр мянган/ төгрөгийн урсгал засвар хийсэн.

Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 2.в.4-т /эмнэлэг, үзвэрлэг, сургуульд зайлиггүй урсгал засвар хийхээс бусад тохиолдолд төсвийн байгууллагын албан контор, ажлын байранд урсгал засвар хийхгүй байх/;

2. Үнэт цаас, үзвэр үйлчилгээ, тайзны шимтгэл зэрэг бэлэн мөнгөөр касст хүлээн авсан 1,503,500.00 /нэг сая таван зуун гурван мянга таван зуун/ төгрөгийн орлогыг хүлээн авч дансанд тушаахдаа анхан шатны баримт хөтлөөгүй, бэлэн мөнгөний тайлан огт гаргаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/, Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.10-д /Мөнгөн кассаар дамжуулан хийгдэх гүйлгээ бүрт орлого зарлагын баримтыг бичнэ/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад ноцол байдал/, 4.1.1-д /нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох

стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Хэмнэлтийн горимд шилжих тухай тогтоолуудыг хэрэгжүүлж ажиллах; Бэлэн мөнгөөр хүлээн авч тайланд тусгасан орлого, зарлагын бүх гүйлгээнд холбогдох анхан шатны баримтыг үйлдэж, бэлэн мөнгөний тайланг гаргаж хэвших;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Цагаандэлгэр сумын Соёлын төвийн төсвийн шууд захирагч Б.Алдармаа, нягтлан бодогч Б.Цэндмаа нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

АУДИТОР




Б.ГАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ

НЯГТЛАН БОДОГЧ



Б.АЛДАРМАА

Б.ЦЭНДМАА